

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Даасанбат БААСАНБАТ*

Огноо: 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

ШИВЭЭГОВЬ СУМАНД ГЭРЭЛТҮҮЛЭГ НЭМЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН САНАЛ  
ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Шивээговь суманд гэрэлтүүлэг нэмэх ажлын  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Төслийн дугаар:

ГСАШГСЗДТГ/202012003

Говьсүмбэр аймаг Шивээговь сум

Нэг. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

2020.08.12

**Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар нь** сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Суманд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажил”, **ГСАШГСЗДТГ/202012003**-ийг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 00** минутаас өмнө битүүмжилсэн цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. “Тооцохгүй”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг,  
Нутгийн удирдлагын ордон, 2-р давхар, 208 тоот өрөө,  
Нийгмийн бодлогын мэргэжилтэн  
3.Баасандалай, 99038561**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн

**саналын  
хүчинтэй  
байх хугацаа**

хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцог залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан      2. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жилд /2018, 2019 онуудын хамгийн багадаа жилд 1-ээс доошгүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. /  <b>Ижил төстэй ажил гэдэг нь гудамж талбайд гэрэлтүүлгийн ажил хийсэн байхыг ойлгох ба ажлын гэрээ, хүлээлцсэн комиссын актын хуулбарыг ирүүлэх.</b>      3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /наториатаар баталгаажуулж ирүүлэх/      4. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /Өргүй байх/      5. Бүх харилцагч банкны тодорхойлолт /өр зээлийн талаарх мэдээлэл/      6. Татварын байгууллагын тодорхойлолт /Өргүй байх/      7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт      8. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 12,6 сая төгрөг. Үүнд: Арилжааны банкны судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлэх      9. Гүйцэтгэх ажлын үе шатны хуваарь, санал болгож буй ажлын төсвийг мэргэжлийн эрх бүхий төсөвчнөөр хийлгүүлж баталгаажуулсан байх,      10. Тухайн ажлыг хариуцаж ажиллах талбайн даамал 1- /Талбайн даамал нь үндсэн ажилтан байх ба цахилгааны инженер мэргэжилтэй, инженерийн диплом, Нийгмийн даатгалын дэвтэр, цахим иргэний үнэмлэхний хуулбар, ажил, мэргэжлийн туршлагыг хүснэгтээр ирүүлэх/      11. Тухайн ажлыг гүйцэтгэх цахилгааны техникич 1- /Үндсэн ажилтан байх ба мэргэжлийн үнэмлэх, Нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхийг хуулбарлан нотариатаар баталгаажуулж ирүүлэх/      12. Тухайн ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтнууд болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтанг томилсон захиралын тушаалыг баталгаажуулан ирүүлэх      13. Тухайн ажлыг хариуцан ажиллах ажилтаныг томилсон эрх бүхий албан тушаалтаны итгэмжлэлийг ирүүлэх      14. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байгаагаа албан мэдэгдлээр ирүүлнэ.      15. Шалгарсан тохиолдолд “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ.      16. Харьяалагдах банк, татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдэл ирүүлнэ.      17. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:          1. <b>БА-6.3 буюу Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт ЭСВЭЛ</b>          2. <b>03.2.2 - /0,4-15 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ/</b>          /Тусгай зөвшөөрлийг гэрээний хамт ирүүлэх ба тусгай зөвшөөрөл олгох, сунгах талаарх тайлбар мэдэгдлийг тооцохгүй болно./      18. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах, чанарын шаардлагыг хангасан зэргийг нотлох баримтыг ирүүлэх.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:              1. Ачааны машин              2. Зориулалтын арагтай машин   </p>

	<p>3. Хөдөлмөр хамгааллын бусад багаж, хэрэгсэл гэх мэт</p> <p>19. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлэх</p> <p>20. Дээрх шаардсан мэдээллийн аль нэгийг ирүүлээгүй нь оролцогчийн саналаас татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, Нутгийн удирдлагын ордон</b></p> <p>Огноо: <b>2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p> <p><b>Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.</b></p> <p>Тендер хүлээн авах этгээд: <b>Нийгмийн бодлогын мэргэжилтэн 3.Баасандалай</b></p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, Нутгийн удирдлагын ордон</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2-р давхар, 208 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 30 минут</b></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Суманд гэрэлтүүлэг нэмэх ажил”-ГСАШГСЗДТГ/202012003</b></p>

БАТЛАВ.  
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СҮМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *О.Далдамжийн* Б.БААСАНБАТ

2020 оны 08 дугаар сарын 10 -ны өдөр



## ШИВЭЭГОВЬ СУМАНД ГЭРЭЛТҮҮЛЭГ НЭМЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1-р баг "Суманд гэрэлтүүлэг нэмэх ажил"-д дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

### 1. Ажилд тавигдах ерөнхий шаардлага

Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажиллах бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг чанд мөрдөн ажиллаж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж зарцуулах
- Гүйцэтгэг нь зохиогч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.
- Ажлыг үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлж, фото зургаар баталгаажуулж, акт үйлдсэний дараа дараагийн ажлыг үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.
- Ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын талбай дээр их хэмжээгээр татахаасаа өмнө дээжийг захиалагчид үзүүлж, зөвшилцөх зарчим баримталж ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй, буруу буюу чанаргүй материал авчирч, ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлаа гүйцэтгэг хариуцна.
- Ажлыг гүйцэтгэх үед дулаан болон холбоо, цахилгааны шугамын утас, газар доорх шугам хоолой, холбоо, цахилгааны утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.
- Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж, иргэдийн зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнуудыг хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангана.
- Барилгын ажлын явцад гарсан хог хаягдлыг зөөвөрлөн, төвлөрсөн хогийн цэгт хаяна. Ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- Ажлын графикт чанарын хяналтын хугацааг тооцож ирүүлэх бөгөөд хугацааг мөрдөж ажиллана.
- Ажлыг гэрээ байгуулнаас хойш хуанлийн 7 хоногт эхлүүлээгүй тохиолдолд гэрээ цуцлах үндэслэл болно.
- Ажилд тушаалаар томилогдсон мэргэжлийн талбайн инженерийг тогтмол ажиллуулах, мэргэжил шаардсан ажилд мэргэжлийн үнэмлэхтэй ажилчдыг ажиллуулах.
- Үнийн санал ирүүлэхдээ төсвийг ЗТБХБСайдын 2012 оны 181 дүгээр тушаал, Барилгын төсөв зохиох заавар, БНБД81-95-12-г мөрдлөг болгох бөгөөд шууд, нэмэгдэл,

ашиг, зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажил зэргийг тооцож ирүүлнэ.

- Автотээврийн зардлыг ЗТАЖЯ-ны сайдын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно. ЗТБХБ-ын сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг БД81-112-11 /Барилгын машин ашиглалтын нэг машин-цагийн жишиг үнэ/-ийн дагуу тооцож ирүүлнэ.

- Гүйцэтгэгч нь ажил хийгдэх талбайн гадна иргэд, олон нийтэд зориулсан тухайн бүтээн байгуулалтыг танилцуулах 2\*4-оос багагүй хэмжээний самбарыг байршуулж, хамгаалалтын зурvas байгуулна.

- Ажил дууссаны дараа гүйцэтгэлийн зургийг гаргаж, захиалагч болон хяналтын байгууллагад ирүүлнэ.

- Гэрэлтүүлэг нэмэх ажлыг 1 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

- Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох, “Зөрчлийн тухай” хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авах эрхтэй болно.

## **2. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага**

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байх. /БНБД стандартад нийцсэн байна./

- Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байна.

- Материал нь шинэ, өмнө ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтээ технологи, хандлагыг бүрэн хангасан байна. Мөн Монгол улсын Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад орсон материалыг заавал авч ашиглах бөгөөд тайланг гүйцэтгэлд тусгаж ирүүлнэ.

- Шаардлага хангасан тухай шинжилгээний бичиггүй түүхий эд, материалыг засварын ажилд хэрэглүүлэхгүй болно.

## **3. Гэрэлтүүлэг, гадна цахилгааны ажилд тавигдах шаардлага**

- Сумын төв талбайн гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн ажлыг хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөл, “Хот тосгон ба, суурин газрын гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх” БД30-102-11, “Цахилгаан техникийн ажил” БНБД3.05.06-90, ”Цахилгаан байгууламжийн дүрэм” БД43-101-03 барилгын норм, цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, цахилгааны тоног төхөөрөмж ашиглалтын үед мөрдөх дүрмүүдийн дагуу хийж гүйцэтгэх ба ажлын зураг төсвийг баримтлан гүйцэтгэх шаардлагатай.

- Гэрэлтүүлгийн өнгө үзэмж, загвар хийцийг, урьдчилан фото зураг, гарал үүслийн гэрчилгээнд үндэслэн захиалагчтай зөвшилцэж нийлүүлнэ.

- Гэрэлтүүлэгч нь 120 Вт-с доошгүй хүчин чадалтай хурц гэрэлтүүлэмж бүхий диодтой цагаан өнгийн лед гэрэлтүүлэгч байна.

- Гэрэлтүүлэг автоматаар удирдах боломжтой байх бөгөөд удирдлагын самбарт асааж унтраах цагийн тохируулгатай цагийн релей сууринуулна.

- Гэрэлтүүлгийн шонг газарт сууринуулахдаа газраас дээш 8м, газраас доош 1,2м гүнд төмөр сууриар чагталж, цутгамал бетон суурьтай хийнэ.

- Гэрэлтүүлгийн шонгийн диаметр: суурин хэсэг 150мм, дээд хэсэг 75мм байх бөгөөд шон тус бүрт гэрэл цацруулагч хуулга байрлуулсан байна.

- Гэрэлтүүлгийн шонгийн байршлыг захиалагч, гүйцэтгэгч талууд хоорондоо зөвшилцэн гаргана.
- Ажил хийгдсэний дараа далдлагдсан ажлын гүйцэтгэлийн схем зургийг гаргаж, ажил хүлээлгэн өгөхөд захиалагч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

**СУМАНД НАРНЫ ЗАЙГААР АЖИЛЛАДАГ ГЭРЭЛТҮҮЛЭГ НЭМЭХ АЖЛЫН ТОО**  
**ХЭМЖЭЭ**

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Цэнэг хураагуур батерей 100 А/Ц	ширхэг	14
2	Нарны панель 100A	ширхэг	14
3	Удирдлагын холбогч	ком	14
4	Монтажийн утас 2*2.5мм	м	1400
5	Салбарлагч /Зажем/	ширхэг	14
6	Гэрэлтүүлгийн толгой /120Вт-аас доошгүй/	ширхэг	14
7	1 толгойтой гэрлийн төмөр багана 8м /газрын түвшнээс/	ширхэг	14
8	Панель тогтоох суурь	ширхэг	14
9	Будаг	кг	22
10	Цемент зуурмаг М100	м3	2
11	Тусгаарлагч лент	кг	0.127
12	Зүүн гэр хорооллын тоглоомын талбайн нарны зайн гэрэлтүүлгийг сэргээн засварлах	ширхэг	4

Боловсруулсан:

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

3.Баасандалай

## Тав. ЗУРАГ

### Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зурийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

## Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

#### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.  |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |  |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br><b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.   |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | <b>9.1.</b> Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнэ. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдолыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br><br><b>9.2.</b> Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдолыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.   |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b>	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
<b>11. Үе шатны ажлын хуваарь</b>	<p><b>B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ</b></p> <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлуулсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p>
<b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b>	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
<b>13. Алданги</b>	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнэ. Алдангийн нийт дун гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
	<b>Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>
<b>14. Ажил дуусгах</b>	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
<b>15. Хүлээж авах</b>	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
<b>16. Эцсийн тооцоо</b>	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
<b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээний ү гарын</b>	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дун нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- |  |  |
|--|--|
| <b>авлага</b>                              | заасан хугацаанд хүлээлгэн өгнө.   |
|  | 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.   |
| <b>18. Гэрээг цуцлах</b>                   | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li><li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;</li><li>(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буудсан;</li><li>(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</li><li>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</li></ul> <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> |
| <b>19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр</b> | <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>   |
| <b>20. Гүйцэтгэлээс чөлөөлөх</b>           | <p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.</p>   |

## Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 2.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Шивээговь суманд гэрэлтүүлэг нэмэх”- **ГСАШГСЗДТГ/202012003**
- ГЕН 2.1** Ажил нь: “Шивээговь суманд гэрэлтүүлэг нэмэх”- **ГСАШГСЗДТГ/202012003**-аас бүрдэнэ.  
Ажлын талбай нь: **Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, , 1-р багт** байршина.
- ГЕН 3.1** Төслийн менежер нь: **Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баасанбат**
- ГЕН 4.1** Ажил эхлэх өдөр: **Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш.**  
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: **Ажил хүлээлгэн өгсөнөөр**
- ГЕН 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш **5** хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- ГЕН 9.1** Чанарын баталгаат хугацаа **3 жил** байна.
- ГЕН 13.1** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн **0,05%** байна.  
Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн **5 %** байна.
- ГЕН 17.1** Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг **[огноо]**-ны дотор гаргаж өгнө.  
  
Гүйцэтгэлийн зургийг ажил хүлээлгэн өгсөний дараа ажлын **10** хоногийн дотор гаргаж өгнө.  
Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сүүтгах төлбөрийн хэмжээ **[ 0 ]** байна.
- ГЕН 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын **[ 0 ]**-иар тооцно.
- Төлбөр** Ажлын гүйцэтгэлийн 70 хувийг хийсний дараа гэрээний 70 хувийн санхүүжилтийг олгох ба ажил дуусч улсын комисст хүлээлгэн өгсөн актыг үндэслэн үлдэгдэл 30 хувийн санхүүжилтийг олгоно.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_  
хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай,  
\_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_  
хүчилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар,  
тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан,  
цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад  
ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын  
\_\_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;

- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]